

**Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан
зардлыг нөхөн төлөх тухай
ГЭРЭЭ**

2015 оны 03 дугаар
сарын 09 ны өдөр

дугаар ХАЗ-2015/04/..15

Улаанбаатар
хот

Ерөнхий зүйл

Нэг талаас Ашигт малтмалын газар, нөгөө талаас ашигт малтмалын ордын MV-016815 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улсын бүртгэлийн албанд бүртгэлтэй 9019012055 тоот гэрчилгээ, 2875993 тоот регистрийн дугаартай "Эслэт" ХХК /цаашид аж ахуйн нэгж/ нь Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр хийсэн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дахь Морин толгой элс, хайрганы орд дээр хийгдсэн геологийн зураглал, судалгааны ажлын зардлуудыг улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэгдүгээр зүйл. Ерөнхий эрэл, урьдчилсан хайгуул, нарийвчилсан хайгуул,
гидрогеологийн хайгуул, зураглалын ажлын зардлын нийт хэмжээ**

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дахь Морин толгой элс, хайрганы орд дээр байрлах MV-016835 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 1944, 1996-1997 онд улсын төсвөөс нийтдээ 3 343,98 төгрөгийн зардал гарсан бөгөөд ноогдох хэмжээг үндэслэн Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн Монгол банкны албан ёсны ханшийг /1\$= 1973,53/ үндэслэн тооцоход 138 784,49 төгрөг буюу 70,33 ам.доллар болж байгааг хоёр тал хүлээн зөвшөөрөв.

Хоёрдугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 1 жилийн хугацаанд төлөх бөгөөд төлбөр хийх өдрийн төгрөг, америк долларын ханшаар тооцож төгрөгөөр эсвэл шууд америк доллараар төлнө.

2015 онд 70,33 ам.долл. /далан ам.доллар гучин гурван цент / ам.доллар
(тоогоор) (үсгээр)

2. Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2.1-т дурьдсан онуудад хийхээр хуваарилсан төлбөрийг тухайн онд хавсралт 1-д заасан байдлаар Төрийн сан банкны төгрөгийн 900000712 Ашигт малтмалын газрын дансанд хийнэ.

3. Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр хийсний дараа уг төлбөр Ашигт малтмалын газрын дансанд орсон эсэхийг шалгаж болно.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2, 3-аар тохиролцсон үүргийн дагуу тухайн улирлын төлбөрөө улиралдаа багтаан хийгээгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу хугацаа хэтэрсэн хоног тутам тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн 0,1 хувиар тэнцэх алданги төлнө.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Амарнамба

Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын хүлээх үүрэг, эрх

1. Энэхүү гэрээний нэгд заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаараа өөрчлөхгүй.
2. Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.
3. Нөхөн төлбөр хийсэн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв эсэхийг магадлахдаа төлбөр хийсэн өдрийн америк доллар ба төгрөгийн Монгол банкаас зарласан албан ёсны ханшийг баримтална.


Дөрөв. Бусад зүйл

1. Ашигт малтмалын газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтын биелэлтийг Ашигт малтмалын газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид хамтран дүгнэж акт үйлдэнэ.
3. Гэрээг гурав хувь үйлдсэн бөгөөд нэг хувийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нэг хувийг Ашигт малтмалын газар, нэг хувийг ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч тус тус хадгална. Гэрээний хувиуд нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ нь хавсралттайгаа нийт гурван хуудаснаас бүрдэнэ.
4. Аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын газар нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг аж ахуйн нэгж хариуцан төлнө.

Гэрээ байгуулсан:

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

Уул уурхайн хэлтсийн
дарга С.Баттулга



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Эслэт” ХХК-ийн
захирал А.Цолмон



Ашигт малтмалын газар & “Эслэт”ХХК-ийн Морин толгой элс, хайрганы ордын Хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ

Хавсралт №1
 14/420,500
 2016.02.02
 2016.02.02
 2016.02.02
 2016.02.02

2015 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2	70,33	2010,8.	14/420,500	2016.02.02 <i>Гүмү</i>
3				
4				